



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

2020 оны 10 дугаар сарын 28
№40 /1142/

**Монгол Улсын Их
Хурлын тогтоол**

**Зарим хууль, Улсын Их
Хурлын бусад шийдвэрийн
төсөл буцаах тухай**

**Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг**

**Улсын Дээд Шүүхийн
танхимын тэргүүнийг
томилох тухай**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

**Хөтөлбөр батлах
тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

448. Зарим хууль, Улсын Их Хурлын
бусад шийдвэрийн төсөл буцаах тухай Дугаар 28 2197

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

449. Улсын аварга цол олгох тухай Дугаар 102 2201

450. Зарим хүмүүсийг анхан болон давж
заалдах шатны шүүхийн шүүгчийн
албан тушаалд томилох тухай Дугаар 103 2201

451. Улсын Дээд Шүүхийн танхимын
тэргүүнийг томилох тухай Дугаар 104 2202

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

452. Журам батлах тухай Дугаар 140 2202

453. Хөтөлбөр батлах тухай Дугаар 141 2209

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 10 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар
хот

Зарим хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хуралд өргөн мэдүүлэгдсэн зарим хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн хууль санаачлагч нь өөрчлөгдсөн,



зарим төслийн талаар шинээр байгуулагдсан Засгийн газрын саналыг авах шаардлагатай тул хавсралтад дурдсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын Их Хурлын 2020 оны
28 дугаар тогтоолын хавсралт

**ХУУЛЬ САНААЧЛАГЧИД НЬ БУЦААХ ХУУЛЬ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН БУСАД ШИЙДВЭРИЙН
ТӨСЛИЙН ЖАГСААЛТ**

1.Баянмонгол (Эрдэнэс Монгол) компанийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн Хүний хөгжил сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Болд, 2012.06.13/;

2.Казиногийн тухай хуулийн төсөл /Монгол Улсын Засгийн газар, 2015.02.12/;

3.Шүүмжлэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Болд, 2016.12.27/;

4.Гэр хорооллын хөгжлийн тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Болд, 2016.12.27/;

5.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Болд, 2016.12.27/;

6.“Бичил уурхай эрхлэгч иргэдийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан, 2016.12.28/;

7.Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Сумъяабазар, Ц.Гарамжав, Н.Оюундарь, Б.Ундармаа, Х.Нямбаатар, Н.Учрал, 2016.12.28/;

8.Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Цэрэнбат, 2016.12.28/;

9.Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатар, Б.Батзориг, 2017.06.02/;

10.Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэ, 2018.04.24/;

11.“Бүгд Найрамдах Казахстан Улсад байнгын оршин сууж байгаа Монгол Улсын иргэд, Монгол Улсад байнга оршин сууж байгаа Бүгд Найрамдах Казахстан Улсын иргэд хялбаршуулсан журмаар харьяат болох, харьяатаас гарах болон иргэний харьяалалгүй болох, хоёрдмол харьяалалтай болох тохиолдлоос урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын хэлэлцээр” байгуулах тухай асуудал /Монгол Улсын Засгийн газар, 2018.06.19/;

12.Нөхөн үржихүйг дэмжих зохицуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарь, Б.Саранчимэг, Ш.Раднаасэд, 2018.06.21/;

13.Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Жавхлан, 2019.06.17/;

14.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Жавхлан, 2019.06.17/;

15.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэ, 2019.07.09/;

16.Итгэлийн зээл олгох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Оюунхорол, 2019.10.02/;

17.“Монгол Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Энхболд, 2019.10.08/;

18.Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Засгийн газар, 2019.10.08/;

19.Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Монгол Улсын Засгийн газар, 2019.12.02/;



20.Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Монгол Улсын Засгийн газар, 2019.12.02/;

21.Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл / Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Дамба-Очир, 2019.12.02/;

22.Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг огцруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, 2020.01.13/;

23.Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Засгийн газар, 2020.03.05/;

24.“Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Засгийн газар, 2020.04.02/;

25.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Цэрэнбат, 2020.04.07/;

26.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Цэрэнбат, 2020.04.07/;

27.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Орон сууцны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Засгийн газар, 2020.04.07/;

28.Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр, 2020.05.05/;

29.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр, 2020.05.05/.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 07 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 102

Улаанбаатар
хот

Улсын аварга цол олгох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 15 дугаар зүйлийн 1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Үндэсний их баяр наадам, Тулгар төрийн 2229, Их Монгол Улсын 814, Ардын хувьсгалын 99 жилийн ойн улсын баяр наадмын Үндэсний бөхийн барилдаанд 9 даван түрүүлсэн Увс аймгийн Давст сумын харьяат, “Алдар” спорт хороо, “Увс нуур” дэвжээний бөх Пүрэвийн Бүрэнтөгсөд “Улсын аварга” цол олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 07 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 103

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 16, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Баасанжавын Эрдэнэхишигийг Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Цэдэвсүрэнгийн Ариунзулыг Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Зүмбэрэллхамын Шүрэнчулууныг Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

2. Өөр шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсонтой холбогдуулан Баасанжавын Эрдэнэхишигийг Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 07 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 104

Улаанбаатар
хот

Улсын Дээд Шүүхийн танхимын тэргүүнийг томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Чулууны Тунгалагийг Улсын Дээд Шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүнээр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 04 дүгээр
сарын 17-ны өдөр

Дугаар 140

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЧИНЗОРИГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛЭЭС ЧӨЛӨӨЛӨХ,
АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САНГААС ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ
ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь дэлхий дахинд үүсээд байгаа цар тахал буюу коронавируст халдвар тархсан онцгой нөхцөл байдлын улмаас улс орны эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал хүндэрч, аж ахуйн нэгж, байгууллагын орлого буурч, үйл ажиллагаа нь доголдож байгаатай холбогдуулан нийт аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчийг дэмжихэд оршино.

1.2.Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага болон даатгуулагч-Монгол Улсын иргэн (цаашид “даатгуулагч” гэх)-ий тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэл (цаашид “нийгмийн даатгалын шимтгэл” гэх)-ийг чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх (цаашид “дэмжлэг” гэх) болон нийгмийн даатгалын сан хооронд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмыг баримтална.

1.3.Энэ журмын 2.1.1-2.1.4-т заасан хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, их, дээд сургууль (цаашид “аж ахуйн нэгж, байгууллага” гэх) тэдгээртэй хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа даатгуулагч, сайн дураар даатгуулагч 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй.

1.4.Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого 2020 оны 4-9 дүгээр саруудын аль нэг сард өмнөх оны мөн үеэс буурсан нь татварын тайлан, татварын төлбөрийн баримтаар баталгаажсан бол “үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурсан” гэж үзнэ.

1.5.Хууль хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа тухайн сарын ажилтны тоогоор “ажлын байрыг хадгалж байгаа” гэж үзнэ.

1.6.Хуулийн 3 дугаар зүйлд заасан төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрт улс, аймаг, нийслэлийн онцгой комиссын тогтоол, аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж тус тус хамаарна.



Хоёр. Хамрах хүрээ

2.1.Хуулийн 1, 2 дугаар зүйлд заасан нөхцөлийг хангасан дор дурдсан аж ахуйн нэгж, байгууллага, түүнтэй хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа даатгуулагч, сайн дураар даатгуулагчийг шимтгэлээс чөлөөлнө:

2.1.1.энэ журмын 1.4, 1.5-д заасан нөхцөл хангасан хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, түүнд ажиллаж байгаа даатгуулагч;

2.1.2.төрийн бус байгууллага, түүнд ажиллаж байгаа даатгуулагч;

2.1.3.их, дээд сургууль, түүнд ажиллаж байгаа даатгуулагч;

2.1.4.сайн дураар даатгуулагч.

2.2.Нийгмийн даатгалд даатгуулах гэрээний хугацаа нь дууссан сайн дураар даатгуулагч хүсэлт гаргасан бол энэ журмын 3.8, 3.9-д заасан хэмжээгээр шимтгэлээс чөлөөлөгдөнө.

2.3.Хуулийн 3 дугаар зүйлд заасан нөхцөлийн аль нэгийг хангасан төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгжтэй энэ журмын 2.1-д заасан гэрээгээр ажиллаж байгаа даатгуулагч ажилгүйдлийн даатгалын сангаас олгох дэмжлэгт хамрагдана.

2.4.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагаас шимтгэлийг нь хариуцан төлсөн даатгуулагчийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгох дэмжлэгт хамруулахгүй.

Гурав. Чөлөөлөгдөх нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг тодорхойлох

3.1.Аж ахуйн нэгж, байгууллага нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан журмын дагуу сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг Нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ.

3.2.Энэ журмын 3.1-д заасан тайланг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчийн чөлөөлөгдөх нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг тодорхойлно.

3.3.Аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчийн чөлөөлөгдөх сарын шимтгэлийн хэмжээ нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын 2020 оны 1, 2, 3 сарын бүрэн олгосон хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан шимтгэлийн дундаж хэмжээнээс илүүгүй байна.

3.4.Хуулийн 1 дүгээр зүйлд заасан нөхцөлийг хангасан улирлын шинжтэй үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад энэ журмын 3.3-т заасан ногдуулах шимтгэлийн хэмжээ хамаарахгүй.

3.5.Аж ахуйн нэгж, байгууллагын 2020 оны 4-9 сард нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдөх даатгуулагчийн тоо нь 2019 оны 4-9 сар, 2020 оны 1-3 саруудын аль өндөр тайлагнасан сарын даатгуулагчийн тооноос ихгүй байна.

3.6.Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдсөн аж ахуйн нэгж, байгууллага нь хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн бол уг шимтгэлийг нийгмийн даатгалын байгууллагаас аж ахуйн нэгж, байгууллагад, аж ахуйн нэгж, байгууллага нь даатгуулагчид тус тус буцаан олгоно.

3.7.Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдөх аж ахуйн нэгж, байгууллага нь хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар дутуу төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх үүрэг хүлээнэ.

3.8.Сайн дураар даатгуулагчийн хувьд чөлөөлөх нийгмийн даатгалын шимтгэлийн нэг сарын хэмжээ 56700 (тавин зургаан мянга долоон зуун) төгрөг байна.

3.9.Хүүхдээ 3 нас хүртэл нь асарч байгаа сайн дураар даатгуулагч эхийн хувьд чөлөөлөх нийгмийн даатгалын шимтгэлийн нэг сарын хэмжээ 26250 (хорин зургаан мянга хоёр зуун тавин) төгрөг байна.

3.10.Сайн дураар даатгуулагч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (420000 төгрөг)-нээс дээш орлогоос шимтгэл төлөхөөр мэдүүлсэн бол уг орлогоос тооцсон шимтгэлийн, энэ журмын 3.8, 3.9-д заасан чөлөөлөх шимтгэлийн зөрүүгээр өөрөө хариуцан төлж болно.

3.11.2020 оны 4-9 сарын нийгмийн даатгалын шимтгэлийг урьдчилан төлсөн сайн дураар даатгуулагчийн хүсэлтийг үндэслэн энэ журмын 3.8, 3.9-д заасан хэмжээгээр төлсөн шимтгэлийг буцаан олгоно.

Дөрөв. Ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх

4.1.Хуулийн 3 дугаар зүйлд заасан нөхцөлийг хангасан аж ахуйн нэгж нь дэмжлэг авах даатгуулагчийн жагсаалт, төлбөрийн нэхэмжлэлийг энэ журмын 3.1-д заасан тайлангийн хамт нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ.



4.2. Аж ахуйн нэгжийн дэмжлэг авах даатгуулагчийн тоо нь 2020 оны 2, 3 дугаар сард тайлагнасан даатгуулагчийн тооноос ихгүй байна.

4.3. Нийгмийн даатгалын байгууллага нь энэ журмын 4.1-д заасан жагсаалт, төлбөрийн нэхэмжлэлийг энэ журмын 3.1-д заасан тайланд үндэслэн нийт дэмжлэгийн хэмжээг хянан баталгаажуулж дараа сарын 20-ны өдрийн дотор аж ахуйн нэгжийн харилцах дансанд шилжүүлнэ.

4.4. Аж ахуй нэгж нь энэ журмын 4.3-т заасны дагуу дэмжлэгийг харилцах дансандаа шилжин орсон өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор ажилтны харилцах дансанд шилжүүлнэ.

4.5. Аж ахуйн нэгж нь энэ журмын 4.4-т заасны дагуу шилжүүлснийг нотлох харилцах дансны хуулгыг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангийн хамт нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ.

4.6. Даатгуулагч 2 ба түүнээс дээш аж ахуйн нэгжид ажилладаг бол дэмжлэгийг давхардуулан олгохгүй.

Тав. Төрийн байгууллагууд мэдээлэл солилцох

5.1. Татварын байгууллага нь аж ахуйн нэгж, байгууллагын оноосон нэр, улсын бүртгэлийн дугаараар дараах мэдээлэл бүхий тусгай өгөгдлийн санг үүсгэж, нийгмийн даатгалын байгууллагыг ашиглах боломжоор хангана:

5.1.1. Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан төлбөрийн баримтын мэдээлэлд үндэслэн 2020 оны 2 болон 3 дугаар сард борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 болон түүнээс дээш хувиар буурсан аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор;

5.1.2. татвар төлөгчийн 2020 оны татварын тайлан, төлбөрийн баримтын мэдээлэлд үндэслэн борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс буураагүй аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг албан татвар тайлагнах хуулийн хугацаа дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор.

5.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдийн оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар бүхий мэдээллийг гаргаж 2020 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын ерөнхий газарт цахим хэлбэрээр хүргүүлнэ.

5.3. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь энэ журмын 1.6-д заасан улс, аймаг, нийслэлийн онцгой комиссын тогтоол, аймаг, нийслэлийн Засаг

даргын захирамжийг үндэслэн үйл ажиллагаа нь түр зогссон аж ахуйн нэгж, байгууллагын оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар бүхий мэдээллийг гаргаж 2020 оны 4 дүгээр сараас эхлэн сар бүрийн 30-ны өдрийн дотор, цаашид сар бүр Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Татварын ерөнхий газарт цахим хэлбэрээр хүргүүлнэ.

5.4.Сангийн яам нь гадаад улс орны зээл, тусламжаар бараа, ажил үйлчилгээ гүйцэтгэж буй хуулийн этгээдийн оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар бүхий мэдээллийг гаргаж сар бүрийн 25-ны дотор Нийгмийн даатгалын ерөнхий газарт цахимаар хүргүүлнэ.

Зургаа. Чөлөөлөх нийгмийн даатгалын шимтгэл, дэмжлэгийн хэмжээг бүртгэх, тайлагнах, тооцоо нийлэх

6.1.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь энэ журмын 5.1-5.4-т заасны дагуу ирүүлсэн мэдээллийг үндэслэн нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдөх, дэмжлэгт хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчийг тодорхойлж холбогдох жагсаалтыг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлнэ.

6.2.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь аж ахуйн нэгж, байгууллага болон даатгуулагчийн чөлөөлөгдөх нийгмийн даатгалын шимтгэл, дэмжлэгийн хэмжээг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, холбогдох тайланг сар бүр гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор цахим болон хэвлэмэл хэлбэрээр Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.

6.3.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь энэ журмын 6.2-т заасан тайланг сар бүр гаргаж, дараа сарын 20-ны өдрийн дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлнэ.

6.4.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь чөлөөлөгдөх нийгмийн даатгалын шимтгэл, дэмжлэгт шаардагдах хөрөнгийн тухайн сарын хэмжээг Сангийн яамтай дараа сарын 25-ны өдрийн дотор тооцоо нийлж, баталгаажуулна.

6.5.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хүлээн авч, тухайн сард ажил олгогчийн болон даатгуулагчийн төлбөл зохих буюу чөлөөлөгдөх шимтгэлийн дүнг тооцон хянан баталгаажуулна.

6.6.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь сайн дураар даатгуулсан даатгуулагчийн чөлөөлөх нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог сар бүр хийж бүртгэл хөтөлнө.



Долоо. Нийгмийн даатгалын сан хооронд хөрөнгө шилжүүлэх

7.1.Хуулийн 4 дүгээр зүйлд заасан нийгмийн даатгалын сан хооронд шилжүүлэн зарцуулах хөрөнгийн хэмжээ, төсвийн нарийвчилсан хуваарийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, сар, улирлын хуваарийг Сангийн сайд тус тус батална.

Найм. Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлсөн хугацааг баталгаажуулах

8.1.Хуулийн 1, 2 дугаар зүйлд заасны дагуу шимтгэлээс чөлөөлөгдсөн хугацааг даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нийт хугацаанд оруулан тооцно.

8.2.Аж ахуйн нэгж, байгууллага нь хуулийн 1 дүгээр зүйлд заасан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдсөн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, шимтгэлийн хэмжээг төлснөөр бүртгэнэ.

8.3.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (байцаагч) нь хуулийн 2 дугаар зүйлд заасан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдсөн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, шимтгэлийн хэмжээг төлснөөр тооцож баталгаажуулна.

8.4.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (байцаагч) нь энэ журмын 8.2-т заасны дагуу хянан баталгаажуулснаар тухайн даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдсөн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлсөнд оруулан тооцно.

Ес. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих

9.1.Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын хяналт, шалгалтын чиг үүрэг бүхий нэгж нь аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, бүртгэх, ногдуулалт хийх, тайлагнах, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр тогтоох, олгох үйл ажиллагаанд хяналт тавина.

9.2.Нийгмийн даатгалын байгууллага нь холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллах бөгөөд худал мэдээлэх, хуурамч баримт бүрдүүлэх зэргээр даатгуулагчийн тоо, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах

орлогын хэмжээг зохиомлоор өсгөсөн аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт явуулна.

Арав. Бусад

10.1.Энэ журмыг хэрэгжүүлэх заавар, түр хэрэглэх маягтын загварыг Нийгмийн даатгалын ерөнхий газар баталж болно.

10.2.Худал мэдээлэх, хуурамч баримт бүрдүүлэх зэргээр даатгуулагчийн тоо, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг зохиомлоор өсгөн нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдсөн, дэмжлэг авсан нь нотлогдсон тохиолдолд гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 04 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 141

Улаанбаатар
хот

Хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.6 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Цагдаагийн албаны тухай хуулийн 16.2, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид үүрэг болгосугай.

3.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг жил бүрийн төсвийн төсөлдөө тусган үе шаттайгаар хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Цагдаагийн ерөнхий газар (С.Баатаржав)-т тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Ц.НЯМДОРЖ



Засгийн газрын 2020 оны
141 дүгээр тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Манай улсад сүүлийн 3 жилд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, хөдөлгөөн, тархалт, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Гэмт хэрэг, шүүн таслах ажиллагааны статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”-ын дагуу тодорхойлж, цаашдын чиг хандлагыг нийгэм, эдийн засаг, эрүүгийн нөхцөл байдалтай уялдуулан авч үзэхэд жилд дунджаар 31 мянга гаруй гэмт хэрэг бүртгэгдэж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 184.8 тэрбум төгрөгийн эд материалын хохирол учирч, 981 хүн нас барж, 10351 хүн бие махбодиороо гэмтэж, эрүүл мэндээрээ хохирсон ба нийт гэмт хэргийн илрүүлэлтийг шинэчлэн баталсан Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлсэн хугацаанд буюу сүүлийн 3 жилийн байдлаар авч үзэхэд 2017 онд 35.6, 2018 онд 36.0, 2019 онд 44.9 хувьтай байна.

Дээрх тоо баримтаас дүгнэхэд манай улсад 5 жилийн дараа буюу 2024 онд гэмт хэрэг 41515 буюу 14.6, гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо 1135 буюу 21.5 хувиар, зам тээврийн осол 2.9 дахин, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 30.0, гэмт хэргийн улмаас нас баралт 10.0, бусдын бие махбодид гэмтэл учруулах зөрчил 15.0 хувиар тус тус өсөх хандлагатай гэсэн төсөөлөл гарч байна¹.

Үндэсний статистикийн хорооны статистик мэдээлэлд үндэслэн, аргачлалын дагуу тооцоолоход 2018 оны байдлаар жилд дунджаар 16 ба түүнээс дээш насны 10.000 хүнд 169 гэмт хэрэг, дэлхийн улс орнуудын 100.000 хүн тутамд харьцуулан тооцоолох аргаар тооцоход жилд дунджаар 16 ба түүнээс дээш насны 100.000 хүнд 1686 гэмт хэрэг тус тус ногдож байгаа нь хүн ам багатай манай улсын хувьд гэмт хэргийн гаралт өндөр байгааг харуулж байна.

Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хар тамхи, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-аас эрхлэн гаргадаг судалгаагаар 2016 оны байдлаар хүнийг санаатай алах гэмт хэргийн улмаас 100.000 хүнд ногдох хэрэг Орос 10.8, Афганистан 6.3, Монгол Улс 5.5, Америк 5.3, Казахстан 4.8, Турк Улс 4.31, Герман, Франц, Бельги, Швед зэрэг улсуудад 1, Хятад 0.62, Япон 0.28 гэсэн үзүүлэлттэй байна².

¹Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Статистик, мэдээллийн хэлтсийн тооцоолол. 2018 он.

²<https://dataunodc.un.org/GSH app- холбоос /National Data/>

Монгол Улсад үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, хүн ам, тээврийн хэрэгслийн нягтрал, газар зүйн байршил, зам харилцааны нөхцөл бусад онцлогийг харгалзан Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор цагдаагийн байгууллагын бүтэц, орон тооны болон автомашин, тусгай хэрэгслийн хангалт, тэдгээрийн эдэлгээний жишиг нормативыг баталсан. Уг тогтоолын дагуу 4000 хүн ам тутамд 1 хэсгийн байцаагч, 15000 хүн ам тутамд 2-оос доошгүй хэв журмын эргүүл, 350 тээврийн хэрэгсэл тутамд 1-ээс доошгүй замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий алба хаагч, 150 км тутамд 1-ээс доошгүй орон нутаг дахь замын хэвтээ, босоо тэнхлэгийн дагуух цагдаагийн хяналтын цэг, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах шууд үүрэг бүхий алба хаагч нийт орон тооны 75-аас доошгүй хувийг эзэлнэ, хөдөлгөөнт эргүүлд 15000 хүн ам тутамд 1-ээс доошгүй, сум дахь цагдаагийн алба хаагчид 1-ээс доошгүй автомашин байхаар тус тус заасан боловч улс орны эдийн засгийн байдлаас шалтгаалан цагдаагийн байгууллагын одоогийн бүтэц, орон тоо, ашиглаж байгаа тээврийн хэрэгслийн тоо энэхүү жишиг нормативт хүрэхгүй, 4000 орчим орон тоогоор бага байгаа нь алба хаагчдын хөдөлмөрлөх эрх зөрчигдөх, эрүүл мэндээр хохирох нөхцөлийг бий болгож байгаа талаар Хүний эрхийн үндэсний комиссоос Улсын Их Хуралд хүргүүлсэн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэлд дурдсан”³.

Бразил Улсад 2010 онд зохион байгуулагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон эрүүгийн хэрэг шүүн таслах асуудлаарх 12 дугаар конгресс дээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын Олон улсын эрүүгийн нөхцөл байдал, шүүн таслах ажиллагааны талаарх илтгэлд “Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 2006 онд дэлхийн 142 орны хууль сахиулах байгууллагыг хамруулан хийсэн хүн хүчний талаарх судалгаагаар 100.000 хүн ам тутамд дунджаар цагдаагийн 300 алба хаагч ногддог.

Дээрх тоо улс орон бүрт харилцан адилгүй байгаа ба зөвхөн 4 улсад 100.000 хүн ам тутамд 100-аас бага, Баруун Ази, Зүүн болон Өмнөд Европын зарим улс орнуудад харьцангуй өндөр (400 орчим) тооны цагдаагийн алба хаагч ногдож байна гэжээ.⁴

Монгол Улсын хувьд нэг алба хаагчид ногдох хүн амын тоо 371 байгаа нь дэлхийн бусад орны дундаж түвшингээс их ачаалалтай ажиллаж байгааг харуулж байна. Мөн гэмт хэрэг, зөрчил шалгах эрх бүхий алба хаагчдын ажлын ачаалал их байгаагаас долоо хоногт 70 хүртэлх цагаар ажиллаж байгаа нь Хөдөлмөрийн тухай хуульд заасан 40 цаг ажиллахаас даруй 75.0 хувиар илүү байна. Тухайлбал, “Ажиглалт” төрийн бус байгууллагаас

³ <http://www.parliament.mn/files/3262>

⁴ <https://undocs.org/A/CONF.213/3>



2018 онд хийсэн “Цагдаагийн байгууллагын зарим ажлын байрны ачааллыг тооцох судалгаа”⁵-гаар 9 ахлах мөрдөгч тутамд 2, 9 мөрдөгч тутамд 2, 11 замын цагдаагийн зохицуулагч тутамд 1, 6 цагдаагийн зохицуулагч тутамд 1, 3 хэсгийн байцаагч тутамд 2, 4 хэсгийн төлөөлөгч тутамд 2, 5 хэрэг бүртгэгч тутамд 2 ажлын байр нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагатай гэсэн дүгнэлт, зөвлөмж гарсан.

Цагдаагийн байгууллагаас 48 төрлийн мэдээллийн сангийн 24 програм хангамж, бэлэн бус торгуулийн болон камерын хяналтын систем зэргийг 2014 оноос үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ашигласнаар 2019 оны байдлаар нийт зөрчлийн 25.0 орчим хувийг камерын хяналтаар илрүүлж, 1.9 сая орчим хүнийг 54 гаруй тэрбум төгрөгөөр торгож, бэлэн бус торгуулийн эргэн төлөлт 60.0 гаруй хувьтай байна⁶.

Мөн жил ирэх тутам хүрээгээ тэлж байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, илрүүлэлтийг ахиулах зорилгоор тандагч, шинжлэгч багаж, рентген тоног төхөөрөмжийг үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашигласнаар энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт 2018 онд 70.0 хувь, 2019 онд 43.2 хувь тус тус өссөн байна⁷.

Гэвч сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэж буй хүн амын төвлөрөл, автомашины импорт, үйлдэгдэж байгаа гэмт хэргийн үйлдлийн арга, техник, технологийн шинэчлэл, хөгжлийн хурдтай нийцүүлэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн дэвшилтэт техник, технологийг өргөнөөр нэвтрүүлэх, үйл ажиллагаанд үр дүнтэй ашиглах шаардлага тавигдаж байна.

Иймд Цагдаагийн албаны тухай хууль (шинэчлэн баталсан)-ийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг Засгийн газар батална” гэж, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.4.6-д “Монгол цагдааг хөгжүүлэх, цагдаа иргэдтэйгээ хамтарч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлнэ” гэж тус тус заасныг үндэслэн дээр дурдсан хэрэгцээ шаардлагыг харгалзан Цагдаагийн албаны тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д нийцүүлэн “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулсан болно.

⁵ Ажиглалт төрийн бус байгууллага. “Цагдаагийн байгууллагын зарим ажлын байрны ачааллыг тооцсон судалгааны тайлан”, 2018 он.

⁶ “Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт” эмхэтгэл. 2019 он.

⁷ Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын статистик мэдээ. 2018, 2019 он.

Энэхүү хөтөлбөрийг цагдаагийн байгууллагын бодлого, төлөвлөлтийг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, сургаж дадлагажуулах, удирдах албан тушаалтны манлайлах ур чадварыг дээшлүүлэх, технологийн шинэчлэл хийх замаар үйл ажиллагааг шуурхай, хүртээмжтэй, дэлхийн өндөр хөгжилтэй орны жишигт хүргэхэд чиглэсэн хөгжлийн зорилго, зорилтыг тодорхойлсон бодлогын баримт бичиг болгохоор зорилоо.

Хөтөлбөр хэрэгжсэнээр цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх чадавх сайжирч, алба хаагчдын мэргэжлийн ур чадвар дээшилж, үйл ажиллагаанд техник, технологийн дэвшлийг өргөнөөр нэвтрүүлэн, Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн гудамж, зам, талбайг камержуулах, хүний нүүр царайгаар таних чадвартай төхөөрөмж (facefinder)-ийг ашиглаж, хүн хүчийг хэмнэх, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, аюулгүйн бүсүүдийг бий болгох, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд бодит ахиц, үр дүн гарна гэж үзэж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1.Хөтөлбөрийн зорилго:

Монгол Улсын цагдаагийн байгууллагын ойрын болон дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангаж, үйл ажиллагааг боловсронгуй болгох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох ажилд орчин үеийн менежментийн хэлбэр, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, үр дүнг дээшлүүлэх, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, мэдлэг, ур чадвар, чадавхыг сайжруулах, иргэдийн аюулгүй, амар амгалан амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

2.2.Хөтөлбөрийн зорилт:

Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

2.2.1.Монгол цагдааг өв тэгш хөгжүүлэн мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, албаны чадамжийг дээшлүүлнэ.

2.2.2.Цагдаагийн албаны бодлого, төлөвлөлт, зохицуулалтын чанарыг дээшлүүлж, байгууллагын чадавхыг сайжруулна.

2.2.3.Үйл ажиллагааны мэргэшсэн байдлыг хангаж, үр дүнг нэмэгдүүлнэ.



2.2.4.Өндөр технологийг нэвтрүүлэх, цагдаагийн инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх замаар үйл ажиллагааны баталгаатай, найдвартай байдлыг хангана.

2.2.5.Иргэдийн оролцоо, бүх талын хамтын ажиллагааг дэмжинэ.

2.3.Хөтөлбөр хэрэгжих хугацаа

2.3.1.Хөтөлбөрийг 2020-2024 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1.шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаанд суурилсан хүний нөөцийн бодлого хэрэгжүүлнэ:

3.1.1.1.хүний нөөцийн үйл ажиллагаа, эрх зүйн актуудын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох дүрэм, журмыг шинэчлэн баталж, мөрдүүлэх;

3.1.1.2.цагдаагийн байгууллагад анх орох иргэнээс авах сонгон шалгаруулалт (ерөнхий шалгалт)-ын үйл ажиллагаанд судалгааны болон техник, технологийн дэвшилтэт арга аргачлалыг нэвтрүүлэх;

3.1.1.3.хүний нөөц, сургалт хариуцсан албан тушаалтнуудыг мэргэшүүлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, байнга хөгжүүлэх;

3.1.1.4.хүний нөөцийн мэдээллийн цахим системийг боловсронгуй болгож, ашиглах.

3.1.2.сургалтын шинэ тогтолцоог нэвтрүүлж, мэргэшсэн алба хаагчийг бэлтгэнэ:

3.1.2.1.сургалтын нэгдсэн төвийн үйл ажиллагааг өргөжүүлж,бүсчилсэн сургалтын 2 төвийг шинээр байгуулах;

3.1.2.2.албаны сургалтын агуулга, технологийг шинэчилж, чадамжид суурилсан сургалтын үйл ажиллагаа явуулах;

3.1.2.3.мэргэжлийн өндөр ур чадвартай, заах арга зүй эзэмшсэн сургагч багшийг бэлтгэж, ажиллуулах.

3.1.3.алба хаагчийн сэтгэл зүйн бэлтгэл, бие бялдрын хөгжлийг сайжруулж, дасан зохицох, үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлнэ:

3.1.3.1. сэтгэл зүйчийн орон тоог нэмэгдүүлж, сэтгэл зүйн үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэх;

3.1.3.2.цагдаагийн үйл ажиллагаанд сэтгэл зүйн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх чадварыг нэмэгдүүлж, мэргэшүүлэх;

3.1.3.3.биеийн тамир, спортын цогцолбор байгуулж, алба хаагчдын бие бялдрын хөгжлийг сайжруулах;

3.1.3.4.алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад алба хаагчийн бие бялдрыг хөгжүүлэх өрөөг тохижуулж, тоноглох;

3.1.3.5.цагдаагийн албанд шинээр болон шилжин томилогдсон, цэргийн байнгын тэтгэвэрт гарах алба хаагчийг тусгай хөтөлбөрт хамруулах.

3.1.4.харилцааны соёл, эерэг хандлагыг төлөвшүүлж, алба хаагчийн ёс зүйг дээшлүүлнэ:

3.1.4.1.алба хаагчдад сэтгэлгээний эерэг хандлага төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх төрөл бүрийн ажил, арга хэмжээг зохион байгуулж хэвшүүлэх;

3.1.4.2.сургах, урамшуулах, хариуцлага тооцох олон талт арга хэмжээгээр алба хаагчийн харилцааны соёл, ёс зүйг дээшлүүлэх.

3.1.5.хувь хүний хөгжлийг дэмжин алба хаагчийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлнэ:

3.1.5.1.алба хаагчаас гаргасан шинэ бүтээл-оновчтой санал, санаачилгыг урамшуулан дэмжиж, тэргүүн туршлагыг дэлгэрүүлэх;

3.1.5.2.хувь хүн өөрийгөө хөгжүүлэх, бие даан суралцах хүсэл эрмэлзлийг бүх талаар дэмжих;

3.1.5.3.Монгол хэл, бичиг, соёлыг уламжлан өвлөх, үндэсний ёс, зан үйлийг танин мэдэх, хэрэглэж занших талаар сургалт, соёл, хүмүүжлийн ажлыг тогтмол явуулж хэвших.



3.2.Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1.цогц бодлого, нэгдмэл төлөвлөлт, ухаалаг зохицуулалттай удирдлагын тогтолцоог бэхжүүлнэ:

3.2.1.1.цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;

3.2.1.2.гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрөөс баримтлах бодлогын баримт бичиг боловсруулж, хэрэгжүүлэх;

3.2.1.3.мэдээлэлд суурилсан үйл ажиллагаа явуулах замаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны шуурхай байдал, чанарыг сайжруулах бодлого хэрэгжүүлэх;

3.2.1.4.тулгамдсан асуудлын шийдэлд чиглэсэн цагдаагийн уян хатан бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

3.2.1.5.иргэд, олон нийтийн дэмжлэг, туслалцаатайгаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хүртээмжтэй байлгах бодлогыг эрчимжүүлэх;

3.2.1.6.цагдаагийн удирдлагын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, эрх зүйн орчныг сайжруулах;

3.2.1.7.байгууллагын төлөвлөлтөд үйл ажиллагаа үр ашигтай, үр дүнтэй байх зарчмыг мөрдлөг болгон эдийн засгийн хувьд үр ашигтай байх бодлого хэрэгжүүлэх;

3.2.1.8.цагдаагийн удирдлагын үйл ажиллагаанд маркетингийн удирдлагын арга, технологийг нэвтрүүлэх бодлого хэрэгжүүлэх;

3.2.1.9.цагдаагийн удирдлагын үйл ажиллагааг шуурхай, тасралтгүй, уялдаа холбоотойгоор явуулах ухаалаг зохицуулалтын бодлого хэрэгжүүлэх.

3.2.2.цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бэхжүүлж, эрх мэдэл, нөөцийг зөв хуваарилж, байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлнэ:

3.2.2.1.нутаг дэвсгэрийн онцлог, хүн ам, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд тохируулан нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах;



3.2.2.2.цагдаагийн байгууллагын орон тоо, автомашин, тусгай хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлж, тэдгээрийн эдэлгээ, ашиглалтын нормативыг шинэчлэн баталж мөрдүүлэх.

3.2.3.удирдахуйн ухааны шилдэг аргуудыг бүх шатанд нэвтрүүлж, удирдлагын манлайллыг дээшлүүлж, хүний хөгжил төлөвшилтийн орчин бүрдсэн, тасралтгүй суралцагч байгууллага болно:

3.2.3.1.цагдаагийн төлөвлөлтийн чиг үүргийн хүрээнд стратегийн, хөтөлбөрийн, шийдвэр гаргалтын, инновацийн, төслийн, маркетингийн, өөрчлөлтийн, харилцааны, эрсдэлийн, цагийн удирдлагын аргуудыг нэвтрүүлэх;

3.2.3.2.цагдаагийн зохион байгуулалтын чиг үүргийн хүрээнд: Системийн, үйл ажиллагааны, сүлжээний, мэдээлэл технологийн, олон нийтийн харилцааны, хэрэглэгчийн харилцааны, логистикийн, оффисын, хямралын удирдлагын аргуудыг нэвтрүүлэх;

3.2.3.3.цагдаагийн удирдлагын манлайлалд чадамжийн, хүний нөөцийн, суралцагч байгууллагын, мэдлэгийн, зөрчилдөөний, сэтгэл судлалын, албан тушаалын, багийн удирдлагын аргуудыг нэвтрүүлэх;

3.2.3.4.цагдаагийн удирдлагын хяналтын чиг үүргийн хүрээнд бүтээмжийн, гүйцэтгэлийн, чанарын, нөөцийн, санхүүгийн удирдлагын аргуудыг нэвтрүүлэх;

3.2.3.5.удирдах албан тушаалтныг сургах, мэргэшүүлэх, давтан сургах нэгдсэн тогтолцоог бий болгох.

3.2.4.байгууллагын аюулгүй байдлыг хангах, алба хаагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хууль зүй, эдийн засаг, нийгмийн баталгааг сайжруулах бодлогыг хэрэгжүүлнэ:

3.2.4.1.цагдаагийн алба хаагчийн цалинг бусад хуулийн байгууллагуудын жишигт нийцүүлэн үе шаттайгаар нэмэгдүүлэх;

3.2.4.2.цагдаагийн алба хаагч, ажилтан, ахмадуудын эдийн засгийн болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлэх;

3.2.4.3.алба хаагчийн нийгмийн баталгааг хангах, ахуй амьдралд нь тусалцаа, дэмжлэг үзүүлэх зорилгоор “Бичил цэцэрлэг”, “Хүүхдийн өдөр өнжүүлэх”, “Хүүхэд харах үйлчилгээ” үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий иргэд, байгууллагатай хамтран ажиллаж, алба хаагчдын хүүхдийг хөнгөлөлттэй үнээр хамруулах арга хэмжээг зохион байгуулах;



3.2.4.4. нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагчийг орон байр, хүнс, тээвэр, холбооны хэрэгслээр хангах, томилогдсон алба хаагч, түүний гэр бүлийн гишүүдэд дэмжлэг үзүүлэхэд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж, цагдаагийн алба хаагчийн гэр бүлийн гишүүдийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх;

3.2.4.5. алба хаагчийн ажиллах нөхцөл, эрүүл мэндийн баталгааг сайжруулах бодлогыг баталж, хэрэгжүүлэх;

3.2.4.6. байгууллагын үнэт зүйл, үйл ажиллагааны залгамж чанарыг хадгалах зорилгоор ахмад ажилтны мэдлэг, туршлагыг бүтээлчээр ашиглах, өвлүүлэх бодлого хэрэгжүүлэх;

3.2.4.7. байгууллага, алба хаагчийн эрх ашгийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг сайжруулж, тэдний хуулиар хүлээсэн баталгааг бүрэн эдлүүлэх.

3.2.5. хяналт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлж, харилцан ажиллагааны уялдаа холбоо, чанар, үр дүнг дээшлүүлнэ;

3.2.5.1. байгууллагын дотоод хяналт болон дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах;

3.2.5.2. цагдаагийн байгууллагад үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх;

3.2.5.3. цагдаагийн байгууллагын гүйцэтгэлийн болон эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах;

3.2.5.4. цагдаагийн байгууллагаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний талаар хэрэглэгчдийн үнэлгээг хөндлөнгийн судалгааны байгууллагаар хийлгэн, дүгнэлт, зөвлөмж гаргуулж, түүний үр дүнг үйл ажиллагаандаа тусган сайжруулах;

3.2.5.5. цагдаагийн байгууллагын хууль тогтоомж, үйл ажиллагааны стандарт, журмыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн байнга боловсронгуй болгож, алба хаагчдад хүртээмжтэй хүргэж, мөрдүүлэх;

3.2.5.6. байгууллагын хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;

3.2.5.7. цагдаагийн байгууллагад иргэдийн хяналтын тогтолцоог төлөвшүүлж, тэдний дэмжлэгийг тусган хэрэгжүүлэх замаар үйл ажиллагааны шуурхай байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх.

3.3.Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1.гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг олон улсын жишигт ойртуулна:

3.3.1.1.гадаад улсын цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн тэргүүн туршлагыг судалж, нэвтрүүлэх;

3.3.1.2.гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны арга хэлбэрийг боловсронгуй болгож, шинжлэх ухааны ололт, техникийн дэвшлийг өргөнөөр ашиглах;

3.3.1.3.Монгол Улсын иргэний бүртгэлийн мэдээллийн санд байгаа иргэний биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хээ)-д суурилсан мэдээллийн санг гэмт хэрэг илрүүлэх ажилд ашиглах боломжийг судлах.

3.3.2.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгож, гэмт хэргийн өсөлт, иргэн, нийгэмд учруулах хор уршгийг бууруулна:

3.3.2.1.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлж, судалгаанд суурилсан ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, аюулгүйн бүсүүдийг бий болгох;

3.3.2.2.гэмт хэргийн дуудлага мэдээллийн байршлыг тодорхойлох GPS төхөөрөмжөөр алба хаагчдыг хангах;

3.3.2.3.эрүүлжүүлэх, саатуулах байр, Монгол Улсад суугаа гадаад улсын Элчин сайдын яамны хамгаалалтын харуулын байр, хөдөлгөөнт хяналтын цэгийн байрны нөхцөлийг сайжруулах;

3.3.2.4.аюултай ачааг тээврийн замд харгалзан хүргэх хамгаалалтын үеийн газар зүйн байршлыг хянах техникийн нөхцөлийг бий болгох;

3.3.2.5.зөрчил гаргасан иргэнд давтан зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн арга хэмжээ, сургалт явуулах зохиомол орчинг бүрдүүлэх;

3.3.2.6.усны, цасны, агаарын бага оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын



журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үйл ажиллагааг сайжруулах.

3.3.3.гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны тактик-арга зүйг сайжруулна:

3.3.3.1.гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны тактик-арга зүйг сайжруулах зорилгоор онол, практикийн бага хурал тогтмол зохион байгуулах;

3.3.3.2.хэргийн газраас ул мөр илрүүлэх, бэхжүүлэх, хураан авахад ашиглах техник хэрэгслийг шинэчилж, шинэ технологийг нэвтрүүлэх;

3.3.3.3.гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон, аюул үүссэн үед хорио цээрийн дэглэм сахиулах, амь нас, эрүүл мэнд нь онц аюултай нөхцөлд байгаа хүнд тусламж үзүүлэх ажиллагаанд оролцох алба хаагчдыг хамгаалах хувцас, хэрэглэл, техник хэрэгслээр хангаж, нөөцийг бүрдүүлж, ашиглах.

3.3.4.мэдээлэлд суурилсан бодлогыг хэрэгжүүлж, албаны шуурхай байдлыг хангана:

3.3.4.1.хөгжлийн бэрхшээлтэй болон хязгаарлагдмал орчинд байгаа иргэдээс дэвшилтэт техник ашиглан дуудлага, мэдээллийг шуурхай хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх;

3.3.4.2.орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан цахим мэдээллийн сангуудыг шинээр нэмэгдүүлж, боловсронгуй болгох;

3.3.4.3.явуулын шуурхай удирдлагын штаб бий болгох.

3.3.5.шинэ мэдлэг, дэвшилтэт техник, технологийг эрчимтэй ашиглана:

3.3.5.1.техник, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэн сайжруулж, байгууллага, алба хаагчийг орчин үеийн дэвшилтэт техник хэрэгслээр хангах;

3.3.5.2.цагдаагийн байгууллагын харьяа нэгжүүдийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис илрүүлэх техник хэрэгсэл, анхан шатны тестээр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;



3.3.5.3.гэмт хэргийн ул мөр илрүүлэх, бэхжүүлэхэд шаардлагатай техник хэрэгслийг үйл ажиллагаанд ашиглах;

3.3.5.4.“Хяналтын нисэх хэсэг”-ийг шинээр байгуулж, цагдаагийн албаны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх ажиллагаанд үр дүнтэй ашиглах.

3.4.Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.4.1.цагдаагийн байгууллагад шинжлэх ухаан, технологийн судалгааны бүтэц, хүний нөөцийг бий болгож, технологи нэвтрүүлэх, инновацийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ:

3.4.1.1.гадаад улс, олон улсын байгууллагаас үзүүлж байгаа зээл, тусламжийн тодорхой хэсгийг цагдаагийн байгууллагын технологийн тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэхэд хуваарилах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3.4.1.2.цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглах техник, технологи, тоног төхөөрөмж, тусгай хэрэгсэл, хэрэглэлд тавих ангилал, шалгуур, баримтлах бодлогыг тодорхойлох;

3.4.1.3.цагдаагийн инновацийн дэд бүтцийг бий болгох чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах;

3.4.1.4.цагдаагийн мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх.

3.4.2.өндөр технологийг нэвтрүүлэх, нутагшуулах, дамжуулах замаар холбоо, техник хэрэгслийн шинэчлэлийг үе шаттайгаар тасралтгүй хэрэгжүүлнэ:

3.4.2.1.теле хяналтын камерын засвар, техник үйлчилгээний зардлыг цагдаагийн байгууллагын төсөвт тусуулах;

3.4.2.2.гэмт хэрэг илрүүлэх, таслан зогсоох, мөрдөн шалгах ажиллагаанд дэвшилтэт техник, технологийг ашиглах;

3.4.2.3.бэлэн бус торгуулийн системийг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэх;

3.4.2.4.био хэмжил зүй, гарын мөрний адилтгалын автомат системийн сүлжээ, станцуудыг төмөр зам, иргэний агаарын тээвэр, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад нэвтрүүлэх;

3.4.2.5.Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагуудын хэмжээнд бие даасан шилэн кабелийн нэгдсэн сүлжээг шинээр бий болгох;

3.4.2.6.Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн гудамж, зам, талбайг камержуулах, хүний нүүр царайгаар таних чадвартай төхөөрөмж (facefinder)-ийг суурилуулж, нэгдсэн удирдлагаар хангах;

3.4.2.7.авто замын хэвтээ, босоо тэнхлэгийг байнгын хяналтад авах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, олон улсын болон улсын чанартай хатуу хучилттай авто замд камерын хяналтын нэгдсэн системийг нэвтрүүлэх;

3.4.2.8.цагдаагийн байгууллагын хэмжээнд богино долгионы болон хэт богино долгионы радио холбооны шинэчлэл хийх;

3.4.2.9.цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээнд аймаг, сум дахь нэгжүүдийг холбох.

3.4.3. цагдаагийн инновацийн “шинжлэх ухаан-үйлдвэрлэл-үйл ажиллагаа”-ны кластерыг үүсгэн инновацийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж, зардлыг хэмнэн үр ашгийг нэмэгдүүлнэ:

3.4.3.1.үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээ, инженер-техникийн дэд бүтцийг хөгжүүлэх;

3.4.3.2.алба хаагчийн зарим төрлийн тусгай хэрэгсэл, зэвсэглэл техникийг үйлдвэрлэх боломжийг судалж, хэрэгжүүлэх;

3.4.3.3.цагдаагийн алба хаагчийн дүрэмт болон хөдөлмөр, аюулгүй байдлыг хангасан хувцсыг дотооддоо үйлдвэрлэх үйл ажиллагааг өргөжүүлэх.

3.4.4.мэдээллийн технологийн дэвшил, програм хангамжийн зөв оновчтой шийдлийг нэвтрүүлж, мэдээллийн аюулгүй байдлыг хангана:

3.4.4.1.цагдаагийн байгууллагын мэдээлэл, холбооны технологийн үйл ажиллагаанд системийн иж бүрэн судалгаа, шинжилгээ хийх;

3.4.4.2.цагдаагийн байгууллагын төрөл мэргэжлийн албадын мэдээллийн систем, мэдээлэл нэгтгэн боловсруулах програмыг нэгдмэл байдлаар боловсруулж, нэвтрүүлэх;

3.4.4.3.байгууллагын үйл ажиллагаанд “Ухаалаг тайлангийн систем” (Business Intelligence) нэвтрүүлэх;



3.4.4.4.улсын хэмжээнд гэмт хэргийн цахим зураглал (crime map)-ыг цагдаагийн байгууллагын хэмжээнд (ArcGis) нэвтрүүлэх;

3.4.4.5.цагдаагийн байгууллагын цахим архивын санг бий болгож, архивын үйлчилгээнд бүрэн шилжүүлэх;

3.4.4.6.байгууллагын удирдлагын цогц системийг сайжруулах;

3.4.4.7.цагдаагийн байгууллагад ашиглаж байгаа серверүүдийг төвлөрүүлэн нэгтгэж “Дата төв” байгуулах;

3.4.4.8.цагдаагийн байгууллагын нэгдсэн системд холбогдож байгаа компьютеруудад албан ёсны лицензтэй програм хангамж ашиглах;

3.4.4.9.Цагдаагийн байгууллагын алба хаагч хаанаас ч байгууллагын дотоод сүлжээний орчноос өөрийн компьютерт хандаж ажиллах боломжтой “Desktop Virtualization” технологийг нэвтрүүлэх.

3.4.5.хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, иргэдийн амь нас, эрүүл мэндэд аюулгүй техник, технологи, тусгай хэрэгслийг ашиглах бодлого хэрэгжүүлнэ:

3.4.5.1.монгол хэл дээрх програм хангамж, платформуудыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг цахимжуулах;

3.4.5.2.хүний амь насанд аюулгүй зэвсэг, хэрэгслийн хангалт, ашиглалтыг нэмэгдүүлж, үйл ажиллагаанд ашиглах.

3.5.Хөтөлбөрийн 5 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.5.1.олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, үйл ажиллагааны шуурхай байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ:

3.5.1.1.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэн, хуулийн этгээдийн оролцоог нэмэгдүүлж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, дэмжих, урамшуулах;

3.5.1.2.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд иргэд, олон нийт, оюутан залуучуудын үүрэг оролцоог идэвхжүүлэх, гадаадын иргэд, жуулчдын аюулгүй байдлыг хангах ажлын үр дүнг дээшлүүлэх;



3.5.1.3.гудамж талбайд үйлдэгдэж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор айл өрхийн дунд хэрэгжүүлсэн хяналтын тогтолцоог хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дунд өргөн нэвтрүүлж, аюулгүй орчныг бүрдүүлэх;

3.5.1.4.“Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны өдөр”-ийг бий болгож, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны ач холбогдол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг сурталчлах, соён гэгээрүүлэх ард иргэдийн цагдаад итгэх итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

3.5.1.5.олон нийтийн цагдаагийн ажилтны ажиллах эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, энэ чиглэлээр аймаг, нийслэлийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дэмжлэг авч, хамтран ажиллах;

3.5.1.6.хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах холбоотой хамтран тэдний эрх ашгийг хамгаалах, үзүүлэх үйлчилгээний стандартыг боловсруулах;

3.5.1.7.гэрээт харуул болон хувийн хамгаалалтын ажил эрхэлж байгаа хуулийн этгээдийг олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам хамгаалах тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг бий болгож хэрэгжүүлэх.

3.5.2.аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах бусад байгууллагатай харилцан, хамтран ажиллах түвшинг ахиулна:

3.5.2.1.аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах бусад байгууллагатай харилцан ажиллах үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх;

3.5.2.2.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, терроризм, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр олон улсын цагдаагийн байгууллагуудтай хамтран ажиллах эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгож, хамтарсан сургалт зохион байгуулах;

3.5.2.3.террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа, онцгой нөхцөл үүссэн үед ажиллах чиглэлээр явуулах дадлага, сургалтыг тогтмол зохион байгуулах.

3.5.3.цагдаагийн байгууллагын гадаад харилцааг өргөжүүлж, үйл ажиллагааг идэвхжүүлнэ:

3.5.3.1.гадаад орнуудын цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгож, хамтын ажиллагааг өргөжүүлэх;

3.5.3.2.Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд цагдаагийн алба хаагчийн оролцоог нэмэгдүүлж, үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх;

3.5.3.3.өндөр хөгжилтэй улс орнуудад алба хаагчдыг мэргэшүүлэн сургах, сургагч багш, мэргэжилтэн урьж ажиллуулах тоог нэмэгдүүлэх;

3.5.3.4.сургалтын нэгдсэн төвийн материаллаг баазыг бэхжүүлж, алба хаагчдад гадаад хэлний мэдлэг эзэмшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах.

3.5.4.олон улсын байгууллага, гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдтэй үр дүнтэй хамтран ажиллана:

3.5.4.1.олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр албаны чадавхыг сайжруулах сургалт зохион байгуулах, төсөл хэрэгжүүлэх зэргээр хамтран ажиллах;

3.5.4.2.цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх сайн дурынхны үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор “Цагдаагийн сайн дурын ажилтан” арга хэмжээг хэрэгжүүлэх.

3.5.5.олон нийттэй харилцах, мэдээлэл харилцааны үр ашгийг нэмэгдүүлнэ:

3.5.5.1.олон нийтийн дунд “Монгол цагдаа” брэндийг бий болгож, бүх талаар сурталчлах, иргэдийн итгэл хүндэтгэлийг бий болгох;

3.5.5.2.байгууллагын хэмжээнд мэдээлэл харилцааны стратеги боловсруулж, хэрэгжүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

4.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

4.1.1.Цагдаагийн байгууллага мэргэшсэн, чадварлаг хүний нөөцөөр бэхжиж, алба хаагчийн эрх зүйн байдал, эдийн засаг, нийгмийн баталгаа сайжирна;

4.1.2.Удирдахуйн шилдэг технологийг бүх шатанд нэвтрүүлснээр бүтэц зохион байгуулалтын оновчтой тогтолцоо бий болж, бодлогын хэрэгжилт, зохицуулалтын чанар дээшилнэ;



4.1.3.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулснаар 100.000 хүнд ногдох гэмт хэргийн гаралтыг 1.0 хүртэл хувиар бууруулж, зам тээврийн ослоор 100.000 хүнд ногдох нас баралтыг 2 хүртэл нэгжээр багасгана;

4.1.4.Шинэ мэдлэг, дэвшилтэт техник, технологийг эрчимтэй нэвтрүүлснээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны баталгаатай, найдвартай, хүртээмжтэй байдал хангагдаж, эдийн засгийн үр ашиг дээшилнэ;

4.1.5.Цагдаагийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн хамтын ажиллагааг бүх талаар идэвхжүүлж, сайн түншлэлийн үр дүнд амар тайван, аюулгүй амьдрах бүс бий болсон байна.

4.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	
			Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт
Зорилт 1. Монгол цагдааг өв тэгш хөгжүүлэн мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, албаны чадамжийг дээшлүүлнэ.						
1.1. Шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаанд суурилсан хүний нөөцийн бодлого хэрэгжүүлнэ.	Мэдлэг, мэргэжлийн ур чадвартай, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган, цахим мэдээллийн системийг хөгжүүлсэн байх;	Хувь	2019	70%	2024	100%
1.2. Сургалтын шинэ тогтолцоог нэвтрүүлж, мэргэшсэн алба хаагчийг бэлтгэнэ.	Чадамжид суурилсан сургалтын агуулга, технологиор алба хаагчдыг мэргэшүүлж, бүсчилсэн сургалтын төвийг шинээр байгуулсан байх;	Хувь	2019	60%	2024	100%
		Тоо		2		
1.3. Алба хаагчийн сэтгэл зүйн бэлтгэлжилт, бие бялдрын хөгжлийг сайжруулж, дасан зохицох, үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлнэ.	-Биеийн тамир, спортын цогцолбор байгуулж, алба хаагчдын бие бялдрын хөгжил, дасан зохицох, үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн байх; -Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн	Хувь	2019	20%	2024	80%



	байгууллага бүрт бие бялдрыг хөгжүүлэх өрөөг тохижуулж, тоноглон; -сэтгэл зүйчийн орон тоог нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн үйлчилгээ үзүүлсэн байх;					
1.4. Харилцааны соёл, эерэг хандлагыг төлөвшүүлж, алба хаагчийн ёс зүйг дээшлүүлнэ.	Алба хаагчдын харилцааны соёл, эерэг хандлага төлөвшиж, ёс зүйн зөрчил буурсан байх;	Хувь	2019	12%	2024	10%
1.5. Хувь хүний хөгжлийг дэмжин алба хаагчийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлнэ.	Алба хаагчаас өөрийгөө хөгжүүлэх, бие даан суралцах хүсэл эрмэлзлэлийг дэмжиж, шинэ бүтээл-оновчтой санал, санаачилгыг урамшуулж, тэргүүн туршлагыг дэлгэрүүлсэн байх;	Хувь	2019	30%	2024	100%
Зорилт 2. Бодлого, төлөвлөлт, зохицуулалтын чанарыг дээшлүүлж, байгууллагын чадавхыг сайжруулна.						
2.1. Цогц бодлого, нэгдмэл төлөвлөлт, ухаалаг зохицуулалттай удирдлагын тогтолцоог сайжруулна.	Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрөөс баримтлах бодлогын баримт бичиг боловсруулж, хэрэгжүүлсэн байх;	Хувь	2019	30%	2024	100%
2.2. Цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бэхжүүлж, эрх мэдэл, нөөцийг зөв хуваарилж, байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлнэ.	Нутаг дэвсгэрийн онцлог, хүн ам, эрүү, хэв журмын нөхцөл байдалд тохируулан нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулсан байх;	Хувь	2019	60%	2024	100%
2.3. Удирдахуйн ухааны шилдэг ухааны шилдэг аргуудыг бүх шатанд нэвтрүүлж, удирдах бүх шатанд нэвтрүүлж, удирдлагын манлайллыг	Удирдахуйн ухааны шилдэг аргуудыг бүх шатанд нэвтрүүлж, удирдах албан тушаалтнуудыг мэргэшүүлэх болон давтан сургалтад хамруулсан байх;	Хувь	2019	20%	2024	100%



дээшлүүлж, хүний хөгжил төлөвшилтийн орчин бүрдсэн, тасралтгүй суралцагч байгууллага болно.						
2.4. Байгууллагын аюулгүй байдлыг хангах, алба хаагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хууль зүй, эдийн засаг, нийгмийн баталгааг сайжруулах бодлогыг хэрэгжүүлнэ.	Байгууллага, алба хаагчийн эрх ашиг, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлж, алба хаагчийн цалинг хууль хяналтын байгууллагуудын жишигт нийцүүлсэн байх;	Хувь	2019	17%	2024	30%
2.5. Хяналт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлж, харилцан ажиллагааны уялдаа холбоо, чанар, үр дүнг дээшлүүлнэ.	-Эрсдэлийн болон гүйцэтгэлийн удирдлагыг нэвтрүүлж, үр дүнд суурилсан дотоод аудит, х я н а л т - ш и н ж и л г э э , үнэлгээний тогтолцоог хөгжүүлсэн байх; -Иргэдийн хяналтын тогтолцооны чанар, үр дүнг дээшлүүлсэн байх;	Хувь	2019	40%	2024	100%
Зорилт 3. Үйл ажиллагааны мэргэшсэн байдлыг хангаж, үр дүнг нэмэгдүүлнэ.						
3.1. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг олон улсын жишигт ойртуулна.	Гадаадын бусад орны цагдаагийн байгууллагын үр дүнд хүрсэн тэргүүн туршлага, шинжлэх ухааны ололт, техникийн дэвшлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, олон улсын жишигт нийцүүлсэн байх;	Хувь	2019	50%	2024	80%
3.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгож, гэмт хэргийн өсөлт, иргэн, нийгэмд учруулах хор уршгийг бууруулна.	Судалгаанд суурилсан урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, аюулгүйн бүсүүдийг бий болгон, гэмт хэргийн гаралтыг бууруулсан байх;	Хувь	2019	+4.9%	2024	-2.0%



<p>3.3. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны тактик-арга зүйг сайжруулна.</p>	<p>-Хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн тактик-арга зүйг сайжруулах зорилгоор онол, практикийн бага хурал жил бүр зохион байгуулсан байх; -техник хэрэгслийг шинэчилж, шинэ технологийг нэвтрүүлсэн байх;</p>	<p>Хувь</p>	<p>2019</p>	<p>30%</p>	<p>2024</p>	<p>100%</p>
<p>3.4. Мэдээлэлд суурилсан бодлогыг хэрэгжүүлж, албаны шуурхай байдлыг хангана.</p>	<p>Үйл ажиллагаанд дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлж, цахим мэдээллийн сан түүний баяжилт, ашиглалтыг нэмэгдүүлж, хөдөлгөөнт явуулын шуурхай удирдлагын штаб бий болгосон байх;</p>	<p>Хувь</p>	<p>2019</p>	<p>50%</p>	<p>2024</p>	<p>100%</p>
<p>3.5. Шинэ мэдлэг, дэвшилтэт техник, технологийг эрчимтэй ашиглана.</p>	<p>-Үйл ажиллагаанд шаардлагатай техник хэрэгслийг үе шаттайгаар шинэчилсэн байх; -"Хяналтын нисэх хэсэг"-ийг шинээр байгуулсан байх;</p>	<p>Хувь</p>	<p>2019</p>	<p>20%</p>	<p>2024</p>	<p>80%</p>
<p>Зорилт 4. Өндөр технологийг нэвтрүүлэх, цагдаагийн инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх замаар үйл ажиллагааны баталгаатай, найдвартай байдлыг хангана.</p>						
<p>4.1. Цагдаагийн шинжлэх ухаан, технологийн судалгааны бүтэц, хүний нөөцийг бий болгож, технологи нэвтрүүлэх, инновацийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.</p>	<p>-Олон Улсын стандартад нийцсэн техник, технологийг нэвтрүүлсэн байх; -"Хууль сахиулах салбарын инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх (2015-2025 он) хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж, цагдаагийн инновацийн дэд бүтцийг бий болгосон байх;</p>	<p>Хувь</p>	<p>2019</p>	<p>20%</p>	<p>2024</p>	<p>80%</p>
<p>4.2. Өндөр технологийг нэвтрүүлэх, нутагшуулах, дамжуулах замаар холбоо, техник хэрэгслийн шинэчлэлийг үе шаттайгаар тасралтгүй хэрэгжүүлнэ.</p>	<p>Хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд теле хяналтын камер, адилтгалын автомат систем, радио холбооны шинэчлэл, дэвшилтэт техник, технологийг үе шаттайгаар нэвтрүүлсэн байх;</p>	<p>Хувь</p>	<p>2019</p>	<p>10%</p>	<p>2024</p>	<p>90%</p>



<p>4.3. Цагдаагийн инновацийн “шинжлэх ухаан-үйлдвэрлэл-үйл ажиллагаа”-ны кластерыг үүсгэн инновацийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж, зардлыг хэмнэн үр ашгийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Дүрэмт хувцас, тусгай хэрэгсэл дотооддоо үйлдвэрлэх нэгж, тусгай зориулалтын техник хэрэгслийн чанар стандартыг судлан тогтоох лаборатори байгуулсан байх;</p>	Тоо	2019	0	2024	1
<p>4.4. Мэдээллийн технологийн дэвшил, програм хангамжийн зөв оновчтой шийдлийг нэвтрүүлж, мэдээллийн аюулгүй байдлыг хангана.</p>	<p>Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд системийн шинжилгээ хийж, төрөл мэргэжлийн албадад шаардлагатай технологийг нэвтрүүлэн, нэгдсэн “Дата төв” байгуулсан байх;</p>	Хувь	2019	40%	2024	100%
<p>4.5. Хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, иргэдийн амь нас, эрүүл мэндэд аюулгүй техник, технологи, тусгай хэрэгслийг ашиглах бодлого хэрэгжүүлнэ.</p>	<p>-Иргэдэд хүргэх үйлчилгээг цахимжуулж, шуурхай хүргэх;</p> <p>-Аминд үл хүрэх тусгай хэрэгслийн хангалт, ашиглалтыг нэмэгдүүлж, үйл ажиллагаандаа ашигласан байх;</p>	Тоо Хувь	2019	6 20%	2024	10 80%
<p>Зорилт 5. Иргэдийн оролцоо, бүх талын хамтын ажиллагааг дэмжинэ.</p>						
<p>5.1. Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлж, үйл ажиллагааны шуурхай байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Олон нийттэй харилцах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг нийгмийн эрэлт, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгож, хамтын хяналтын тогтолцоог хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дунд нэвтрүүлж, аюулгүй орчныг бүрдүүлсэн байх;</p>	Хувь	2019	20%	2024	60%
<p>5.2. Аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах бусад байгууллагуудын хамтын ажиллагааны чанарыг дээшлүүлж, онцгой нөхцөл байдал үүссэн үед хамтран ажиллах ахиулна.</p>	<p>Аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах бусад байгууллагуудын хамтын ажиллагааны чанарыг дээшлүүлж, онцгой нөхцөл байдал үүссэн үед хамтран ажиллах чиглэлээр явуулах</p>	Тоо	2019	3	2024	6



	дадлага, сургалтыг зохион байгуулсан байх;					
5.3. Цагдаагийн байгууллагын гадаад харилцааг өргөжүүлж, үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	Гадаад улсын цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлж, алба хаагчдыг мэргэшүүлэн сургах, сургагч багш, мэргэжилтэн урьж ажиллуулах, гадаад хэлний мэдлэг эзэмшүүлэх сургалт зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;	Хувь	2019	30%	2024	90%
5.4. Олон улсын байгууллага, гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдтэй үр дүнтэй хамтран ажиллана.	Олон улсын байгууллагын санхүүжилт, дэмжлэгтэйгээр албаны чадавхыг сайжруулах сургалт зохион байгуулах, хамтарсан төсөл хэрэгжүүлсэн байх;	Хувь	2019	50%	2024	90%
5.5. Олон нийттэй харилцах, мэдээлэл харилцааны үр ашгийг нэмэгдүүлнэ.	Аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах бусад байгууллагуудын хамтын ажиллагааны чанарыг дээшлүүлж, онцгой нөхцөл байдал үүссэн үед хамтран ажиллах чиглэлээр явуулах дадлага, сургалтыг зохион байгуулсан байх;	Тоо	2019	0	2024	2

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- 5.1.1.улсын болон орон нутгийн төсөв;
- 5.1.2.гадаад, дотоодын байгууллагын төсөл, хөтөлбөр;
- 5.1.3.олон улсын байгууллагын зээл, тусламж
- 5.1.4.бусад эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

6.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, санхүүжилтийг шийдвэрлэх, удирдлага зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.



6.2. Хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, мэргэжил, арга зүйгээр хангах, шаардагдах санхүүжилтийг тухайн жилийн төсөвт тусгуулах, биелэлт, үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнах үүргийг цагдаагийн төв байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

6.3. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь нутаг дэвсгэрийн хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг тухайн жилийн төсөвт тусган баталж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана.

Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, эрсдэл

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зорилт, үйл ажиллагааны үр дүнгээр үнэлнэ.

7.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд цагдаагийн төв байгууллага хагас жил тутам, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаргуулж болно.

7.3. Төсөв, санхүүгийн дутагдал, удирдлага, зохион байгуулалтын жигд бус ажиллагаанаас шалтгаалан дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, хязгаарлагдах нөхцөл үүсч болзошгүй.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.25

Индекс: 200003